



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/029/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2025 он

Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч: Я.Самбууням  
Утас:51-261885 Цахим хаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)  
Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 51-261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 51-261885 Цахим хаяг: [chantsaldulamp@audit.gov.mn](mailto:chantsaldulamp@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Ж.Нямцэцэг  
Утас: 51-261740 Цахим хаяг: [nyamtsetsegj@audit.gov.mn](mailto:nyamtsetsegj@audit.gov.mn)  
Аудитор: Т.Баасанцэнд  
Утас: 51-261740 Цахим хаяг: [baasantsendt@audit.gov.mn](mailto:baasantsendt@audit.gov.mn)  
Аудитор: Г.Тэлмүүн  
Утас: 51-261740 Цахим хаяг: [telmuung@audit.gov.mn](mailto:telmuung@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД  
Ц.БААТАРХҮҮ ТАНАА

2025.04.25 № 1613  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,304.6 сая төгрөгөөр давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.Тухайлбал:

- Авлага, өглөгийн 2,758.6 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Төсвийн төсөлд тусгагдаагүй 324.6 сая төгрөгийн арга хэмжээг санхүүжүүлсэн;
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар 2021-2022 онд хийгдэж дуусахаар батлагдсан 165.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт, гүйцэтгэлд захиалагчийн зүгээс хяналт тавиагүйгээс ажил хугацаандаа хэрэгжээгүй, тайлант онд гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 14.2.5, 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.3-т заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд нь 8,665.5 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 13,238.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 52.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан “Цахим аймаг төслийн төхөөрөмж”, “Цахим орчны хүүхэд хамгааллын тоног төхөөрөмж”, “Хороодын цахим үйлчилгээний тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээний хүрээнд хөрөнгө бэлтгэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 471 дүгээр тогтоолоор Дундговь аймгийн орон нутгийн өмчийн газарт 990.9 сая төгрөг, мөн 556 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газарт 1,119.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус шилжүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хариуцан хэрэгжүүлэх 31 арга хэмжээний хэрэгжилтийг тус яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас 83.8 хувьтай үнэлж, тайланг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-д заасны дагуу төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гарган өгч, мэдээллээр бүрэн хангаж ажилласан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАГДЖАВ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>145,936,073.0</b>	<b>152,739,642.3</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,023,437.1	35,106,497.9
33	АВЛАГА	20,941,126.4	27,027,226.6
34	УРЬДЧИЛГАА	11,021,678.2	11,278,841.6
35	БАРАА МАТЕРИАЛ	13,429,960.0	15,427,979.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	60,519,871.4	63,899,096.4
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>366,787,710.6</b>	<b>360,153,948.6</b>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	155,712.1	167,030.7
37200	Үнэт цаас	500.0	500.0
37300	Урт хугацаат зээл	155,212.1	166,530.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	366,631,998.5	359,986,917.9
39200	Биет хөрөнгө	220,571,758.3	213,245,682.2
39300	Биет бус хөрөнгө	139,479,454.0	143,830,941.3
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	6,580,786.2	2,910,294.3
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>512,723,783.6</b>	<b>512,893,590.9</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>114,459,831.8</b>	<b>107,361,886.2</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	34,331,089.9	35,726,582.7
41300	Өглөг	28,004,757.5	31,768,241.2
41400	Урьдчилж орсон орлого	6,326,332.4	3,958,341.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	80,128,741.8	71,635,303.4
42200	Урт хугацаат зээл	80,128,741.8	71,635,303.4
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>398,263,951.9</b>	<b>405,531,704.7</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	394,740,916.7	402,008,669.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,863,456.7	6,863,456.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	227,806,661.7	227,806,661.7
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,538,512.2	2,538,512.2
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	76,483,336.3	80,018,571.0
51200	Хуримтлагдсан үр дүн	38,194,762.1	41,818,327.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,854,187.7	42,963,140.9
52	Хяналтын бус хувь оролцоо	3,523,035.2	3,523,035.2
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>512,723,783.6</b>	<b>512,893,590.9</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>107,183,104.0</b>	<b>105,623,497.5</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,996,046.6	40,881,583.4
120	Нийтлэг татварын бус орлого	41,996,046.6	40,881,583.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,187,057.4	64,741,914.2
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>73,668,565.4</b>	<b>96,102,809.5</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,668,565.4	96,102,809.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,618,070.6	87,607,772.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,716,895.9	20,637,439.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,956,302.6	2,565,680.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,232,768.8	3,821,581.9
2104	Хангамж, бараа материалын зардал	808,769.7	1,165,640.3
2105	Нормативт зардал	5,339.6	27,999.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,433,941.0	1,635,809.3
2107	Томилолт, зочны зардал	472,025.4	935,118.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,418,444.0	33,332,151.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,573,583.7	23,486,351.5
212	ТАТААС	6,094,540.0	1,500,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,955,954.8	6,995,037.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>33,514,538.6</b>	<b>9,520,688.0</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>5,525,276.3</b>	<b>1,370,865.6</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>21,431,459.3</b>	<b>6,067,637.6</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>17,608,355.5</b>	<b>4,823,916.0</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>347,694,552.6</b>	-	<b>347,694,552.6</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,662,024.5	-	3,662,024.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	351,356,577.2	-	351,356,577.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	8,839,620.6	-	8,839,620.6
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(165,531.7)	-	(165,531.7)
7	Өмчид гарсан өөрчилөлт	21,677,940.9	-	21,677,940.9
8	Зарласан ногдол ашиг	(1,403,623.1)	-	(1,403,623.1)
9	Тайлант үеийн үр дүн	17,958,968.0	-	17,958,968.0
<b>10</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>398,263,951.9</b>	-	<b>398,263,951.9</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(858,872.6)	-	(858,872.6)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	397,405,079.3	-	397,405,079.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	137,452.8	-	137,452.8
17	Өмчид гарсан өөрчилөлт	3,535,234.8	-	3,535,234.8
18	Зарласан ногдол ашиг	(369,978.1)	-	(369,978.1)
19	Тайлант үеийн үр дүн	4,823,916.0	-	4,823,916.0
<b>20</b>	<b>2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>405,531,704.7</b>	-	<b>405,531,704.7</b>

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>267,427,609.2</b>	<b>221,897,246.2</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	202,240,551.8	157,155,524.7
120	Нийтлэг татварын бус орлого	202,240,551.8	157,155,524.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,187,057.4	64,741,721.6
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>225,304,424.6</b>	<b>191,191,377.4</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	225,304,424.6	191,191,377.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212,883,209.7	182,842,437.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,888,657.4	59,005,165.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,808,770.0	13,299,437.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,479,365.9	25,634,711.9
2104	Хангамж, бараа материалын зардал	15,966,950.2	18,322,618.0
2105	Нормативт зардал	6,667.4	45,544.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,253,596.7	852,596.9
2107	Томилолт, зочны зардал	546,817.6	730,244.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,392,418.4	56,686,263.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,539,966.0	8,265,855.0
212	ТАТААС	6,094,540.0	1,500,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,326,674.9	6,848,940.0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>42,123,184.6</b>	<b>30,705,868.8</b>

IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>947,440.1</b>	<b>598,742.8</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>37,201,805.1</b>	<b>32,540,866.6</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,201,805.1	32,540,866.6
2200	Дотоод эх үүсвэрээр	37,201,805.1	32,540,866.6
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(36,254,364.9)</b>	<b>(31,942,123.8)</b>
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(2,521,469.9)</b>	<b>(3,680,684.2)</b>
14	Бусад эх үүсвэр	1,165,403.0	27,670.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,686,872.9	3,708,354.4
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>3,347,349.7</b>	<b>(4,916,939.2)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	36,676,087.4	40,023,437.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,023,437.1	35,106,497.9

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>87,490,333,900.00</b>	<b>67,037,607,612.84</b>	<b>20,452,726,287.16</b>	<b>76.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>71,067,323,900.00</b>	<b>61,749,553,870.84</b>	<b>9,317,770,029.16</b>	<b>86.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>61,358,127,900.00</b>	<b>52,128,665,485.61</b>	<b>9,229,462,414.39</b>	<b>85.0</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>18,008,366,900.00</b>	<b>16,958,688,544.40</b>	<b>1,049,678,355.60</b>	<b>94.2</b>
Үндсэн цалин	13,091,417,300.00	12,345,656,438.85	745,760,861.15	94.3
Нэмэгдэл	2,455,063,600.00	1,649,176,770.08	805,886,829.92	67.2
Унаа хоолны хөнгөлөлт	1,181,175,900.00	1,720,975,590.03	(539,799,690.03)	145.7
Урамшуулал	1,280,710,100.00	1,242,879,745.44	37,830,354.56	97.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,249,472,200.00</b>	<b>2,131,614,767.30</b>	<b>117,857,432.70</b>	<b>94.8</b>
Тэтгэврийн даатгал	1,529,641,100.00	1,457,476,357.53	72,164,742.47	95.3
Тэтгэмжийн даатгал	179,957,700.00	170,563,178.52	9,394,521.48	94.8
ҮОМШӨ-ний даатгал	89,979,000.00	83,524,249.78	6,454,750.22	92.8
Ажилгүйдлийн даатгал	89,979,000.00	83,645,902.15	6,333,097.85	93.0
Эрүүл мэндийн даатгал	359,915,400.00	336,405,079.32	23,510,320.68	93.5
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,232,310,300.00</b>	<b>2,091,714,222.39</b>	<b>140,596,077.61</b>	<b>93.7</b>
Гэрэл, цахилгаан	929,976,600.00	852,450,823.32	77,525,776.68	91.7
Түлш, халаалт	121,291,400.00	112,681,465.57	8,609,934.43	92.9
Цэвэр, бохир ус	182,806,900.00	171,058,054.30	11,748,845.70	93.6
Байрны түрээс	998,235,400.00	955,523,879.20	42,711,520.80	95.7
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>831,002,600.00</b>	<b>720,502,793.40</b>	<b>110,499,806.60</b>	<b>86.7</b>
Бичиг хэрэг	260,931,700.00	233,082,046.09	27,849,653.91	89.3
Тээвэр, шатахуун	94,065,000.00	79,369,211.40	14,695,788.60	84.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	232,394,900.00	200,360,844.91	32,034,055.09	86.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,302,700.00	21,808,400.00	9,494,300.00	69.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	212,308,300.00	185,882,291.00	26,426,009.00	87.6
<b>Нормативт зардал</b>	<b>6,867,000.00</b>	<b>266,000.00</b>	<b>6,601,000.00</b>	<b>3.9</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,867,000.00	266,000.00	6,601,000.00	3.9

<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,065,984,600.00</b>	<b>876,030,042.00</b>	<b>189,954,558.00</b>	<b>82.2</b>
Багаж, техник, хэрэгсэл	568,956,100.00	451,222,394.00	117,733,706.00	79.3
Тавилга	39,360,000.00	35,160,100.00	4,199,900.00	89.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,000,600.00	2,291,350.00	6,709,250.00	25.5
Урсгал засвар	448,667,900.00	387,356,198.00	61,311,702.00	86.3
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>810,385,000.00</b>	<b>632,030,977.90</b>	<b>178,354,022.10</b>	<b>78.0</b>
Гадаад албан томилолт	404,709,500.00	323,888,341.90	80,821,158.10	80.0
Дотоод албан томилолт	345,227,100.00	287,499,268.00	57,727,832.00	83.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	60,448,400.00	20,643,368.00	39,805,032.00	34.2
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>20,645,775,700.00</b>	<b>16,159,409,957.46</b>	<b>4,486,365,742.54</b>	<b>78.3</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,754,760,300.00	9,342,501,159.08	4,412,259,140.92	67.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	63,765,000.00	58,300,000.00	5,465,000.00	91.4
Даатгалын үйлчилгээ	5,796,800.00	2,139,871.00	3,656,929.00	36.9
Тээврийн хэрэгслийн татвар	1,516,600.00	318,165.00	1,198,435.00	21.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	118,200.00	-	118,200.00	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,690,891,000.00	6,642,985,822.37	47,905,177.63	99.3
Газрын төлбөр	4,600,400.00	10,500.00	4,589,900.00	0.2
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	13,427,700.00	3,452,840.01	9,974,859.99	25.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	110,899,700.00	109,701,600.00	1,198,100.00	98.9
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,507,963,600.00</b>	<b>12,558,408,180.76</b>	<b>2,949,555,419.24</b>	<b>81.0</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	15,057,579,700.00	12,135,412,887.76	2,922,166,812.24	80.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	450,383,900.00	422,995,293.00	27,388,607.00	93.9
<b>ТАТААС</b>	<b>7,934,196,200.00</b>	<b>7,934,196,200.00</b>	-	<b>100.0</b>
<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	<b>6,434,196,200.00</b>	<b>6,434,196,200.00</b>	-	<b>100.0</b>
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	6,434,196,200.00	6,434,196,200.00	-	100.0
<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>1,500,000,000.00</b>	<b>1,500,000,000.00</b>	-	<b>100.0</b>
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,500,000,000.00	1,500,000,000.00	-	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,774,999,800.00</b>	<b>1,686,692,185.23</b>	<b>88,307,614.77</b>	<b>95.0</b>
<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>1,291,044,500.00</b>	<b>1,282,562,385.23</b>	<b>8,482,114.77</b>	<b>99.3</b>
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,291,044,500.00	1,282,562,385.23	8,482,114.77	99.3
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>483,955,300.00</b>	<b>404,129,800.00</b>	<b>79,825,500.00</b>	<b>83.5</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	69,592,100.00	39,976,800.00	29,615,300.00	57.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,391,600.00	60,150,000.00	2,241,600.00	96.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	351,971,600.00	304,003,000.00	47,968,600.00	86.4
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>16,423,010,000.00</b>	<b>5,288,053,742.00</b>	<b>11,134,956,258.00</b>	<b>32.2</b>
Барилга байгууламж	13,333,010,000.00	2,272,559,252.00	11,060,450,748.00	17.0
Тоног төхөөрөмж	3,090,000,000.00	3,015,494,490.00	74,505,510.00	97.6
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>87,490,333,900.00</b>	<b>70,204,197,725.11</b>	<b>17,286,136,174.89</b>	<b>80.2</b>

<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>78,824,791,700.00</b>	<b>56,963,483,647.14</b>	<b>21,861,308,052.86</b>	<b>72.3</b>
Улсын төсвөөс санхүүжих	78,824,791,700.00	56,963,483,647.14	21,861,308,052.86	72.3
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>8,665,542,200.00</b>	<b>13,240,714,077.97</b>	<b>(4,575,171,877.97)</b>	<b>152.8</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,665,542,200.00	13,238,843,637.97	(4,573,301,437.97)	152.8
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,870,440.00	(1,870,440.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	14,790,119,595.57	(14,790,119,595.57)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	17,956,709,707.84	(17,956,709,707.84)	-
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,011</b>	<b>985</b>	<b>26</b>	<b>97.4</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Төсвийн байгууллага	5	5	-	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>503</b>	<b>490</b>	<b>13</b>	<b>97.4</b>
Удирдах ажилтан	30	20	10	66.7
Гүйцэтгэх ажилтан	436	429	7	98.4
Үйлчлэх ажилтан	37	41	(4)	110.8
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>503</b>	<b>490</b>	<b>13</b>	<b>97.4</b>
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	103	82	21	79.6
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	167	171	(4)	102.4
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	-	100.0
УТҮГ	231	235	(4)	101.7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>3,517,449,223.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>2,193,329,866.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>1,533,647,761.30</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>19,130,000.00</b>
210404	Ном, хэвлэл		19,130,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>56,256,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		7,560,000.00
210602	Тавилга		48,696,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>134,772,640.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		69,700,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		65,072,640.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>1,323,489,121.30</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,323,489,121.30
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>659,682,105.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>405,118,237.50</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		405,118,237.50
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>254,563,868.00</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг		254,563,868.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>1,324,119,356.70</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>1,324,119,356.70</b>
222001	Тоног төхөөрөмж		98,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1,226,119,356.70
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>3,517,449,223.50</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>3,517,449,223.50</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		88,830,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,610,494,386.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		818,124,837.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 14 төсвийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс “Хязгаарлалттай” 5, “Өөрчлөлтгүй” 5 санал дүгнэлт өгч, 3 байгууллага түүвэрт хамрагдсан. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан тайлант онд гүйцэтгэл гараагүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар илэрсэн нийт 4,265.6 сая төгрөгийн залруулагдаагүй нийт зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,304.6 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

#### 3.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн, алдаа зөрчил

Аудитаар нийт 14,391.0 сая төгрөгийн 35 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 14,335.0 сая төгрөгийн 30 алдааг залруулж, 56.0 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 4,209.6 сая төгрөгийн 56 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 231.1 сая төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 3,066.6 сая төгрөгийн зөрчилд 19 албан шаардлага хүргүүлж, 747.4 сая төгрөгийн зөрчилд 26 зөвлөмж, 164.5 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар 1 албан шаардлага хүргүүлээ.

##### 3.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Тайлант онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14,335.0 сая төгрөгийн 30 алдаа, 4,265.6 сая төгрөгийн 61 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой 43,100.6 сая төгрөгийн 30 зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,304.6 сая төгрөгөөр давсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт зөрчлийг 40.0 хувиас доошгүй хувиар бууруулах **албан шаардлага** хүргүүлэв.

#### 3.3 Түүврийн байгууллага

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитаар түүвэрт хамрагдсан 2 байгууллагын санхүүгийн тайланд 171.5 сая төгрөгийн алдааг залруулсан.

Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв нь 116.4 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Тайлант онд худалдан авсан 7.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгүүдийг бараа материалын дансанд бүртгэж, шууд зардалд зарлагдсан;

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсөвт төвлөрүүлсэн 83.8 сая төгрөгийг санхүүжилтийн дүнгээс хасаж тайлагнаагүй;
- Он дамнасан лицензийн төлбөрийг өглөгийн дансаар бүртгэж шууд зардалд хаасан, тайлант онд ногдохгүй зардлыг дараа онд хуваарилан бүртгээгүй байна.

Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба нь нийт 25.0 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүйгээр шууд зардалд бүртгэж зарлагадсан, жилийн эцсийн тайланд үлдэгдлээр толилуулаагүй байна.
- Тайлант онд худалдан авсан 2.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.
- Он дамнасан түрээсийн төлбөрийг өглөгийн дансаар бүртгэж шууд зардалд хаасан, тайлант онд ногдохгүй 19.1 сая төгрөгийн зардлыг дараа онд хуваарилаагүй байна.

Залруулсан алдаа: УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг”, санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй дээрх алдааг аудитын явцад бүрэн залрууллаа.

### 3.3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Кибер аюулгүй байдлын ажлын алба нь төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 13.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, онгоцны тийзний төлбөрт шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;”, 43 дугаар зүйлийн 43.2-т “Зарцуулах эрх нь дараагийн төсвийн жилд дамжсан, энэ хуулийн 43.1.3-т зааснаас бусад төсвийн нийт дүн нь төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн гурван хувиас хэтрэхгүй бөгөөд түүнээс давсан хэсгийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ. “ гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 3.3.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хөрөнгө оруулалтын барьцаа дансанд орон нутагт хийгдсэн 2019-2022 онд гүйцэтгэж, дуусгахаар гэрээ байгуулсан үйлчилгээний нэгдсэн төвийн шинэ барилга, их засварын ажлын 7 аж ахуй нэгж байгууллагад төлөх нийт 129.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна. Уг хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэгч байгууллагууд нь гэрээнд заасан хугацаанд ажлаа дуусгаж, хүлээлцээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8- д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аж ахуйн нэгж байгууллагад төлөх барьцааны өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, гүйцэтгэгч байгууллагуудын гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар батлагдсан “Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл багуудыг шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах” хөрөнгө оруулалтын Багц-5 шилэн кабель суурилуулах 165.9 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Дээр дурьдсан хөрөнгө оруулалтын 5 багц ажлыг Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хавсралтад 2021-2022 онд хэрэгжиж дуусахаар баталж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, 1 үүсгэн байгуулагчтай 2 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан;
- Багц-1 шилэн кабель нийлүүлэх ажил 2022.12.15-нд хугацаа хоцорч нийлүүлэгдсэнээс Багц-5 шилэн кабель суурилуулах ажил улирлын нөхцөл байдлаас шалтгаалан 2022 онд багтан хэрэгжих боломжгүй байдалд хүрсэн;
- Засгийн газрын 2022 оны 414 дүгээр тогтоолыг үндэслэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл гараагүй ажлын санхүүжилтийг барьцаа дансанд байршуулж, 2023 онд тогтоолын хэрэгжих хугацаа дуусч, эрх бүхий байгууллагын шийдвэрээр эх үүсвэрийг улсын төсөвт татсан;
- Багц-5 шилэн кабель суурилуулах ажил хугацаандаа хэрэгжих боломжтой эсэх асуудалд захиалагчийн зүгээс хяналт тавиагүйгээс 2023 оны төсвийн төслийн саналд тусгагдаагүй, 1 жилээр хойшилж, 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдаж санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.6.3-т “төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.3.-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ”, 7.1.3-т “Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн”, Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “харилцан хамаарал бүхий этгээд” гэж тухайн аж ахуй эрхлэгчтэй Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан харилцаа бүхий аж ахуй эрхлэгчийг; Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Нэг этгээд нөгөө этгээдийн, эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой доор дурдсан этгээдийг хоорондоо харилцан хамааралтай этгээд гэж үзнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн хөрөнгө оруулалтад батлагдаж, он дамжин хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт, гүйцэтгэлд захиалагчийн зүгээс хяналт тавиагүй зөрчлийг таслан зогсоож, төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгүүдийг хууль, тогтоомжийн дагуу ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв нь байгууллагын ажилтан сургалтанд хамрагдахаар хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгосон ба хөдөлмөрийн дотоод журамд заагдаагүй 6.0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-т

"Хамтын гэрээгээр зохицуулах харилцааг талууд харилцан тохиролцох бөгөөд ажилтны хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой дараах асуудлыг хамтын гэрээнд тусгаж болно: 37.1.3-т ажил олгогчоос ажилтанд олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн хэмжээ", Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТҮГ-ын захирлын 2024 оны А/29 тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 8.1-д "албан хаагчид тусламж, тэтгэмжийг дараах нөхцлөөр олгоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулагдаагүй асуудалд төсвөөс тэтгэмж олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлээ.

Илрүүлэлт 4: Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв нь Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж 8.7 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно"; 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлээ.

Илрүүлэлт 5: Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв нь төсөвт төлөвлөөгүй 10.2 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг урсгал төсвөөс худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төлөвлөөгүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлээ.

Илрүүлэлт 6: Кибер аюулгүй байдлын ажлын албаны дарга нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/03, А/09 дугаартай тушаалуудаар Америкийн Нэгдсэн Улсад зохион байгуулагдсан ажлын айлчлал болон "Номхон далайн цахилгаан холбооны зөвлөлийн хурал 2024"-д оролцохоор батлагдсан гадаад албан томилолтын төсвөөр удирдамжид заагдаагүй арга хэмжээнд оролцсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан тушаал, төсөв, томилолтын удирдамжийн дагуу албан томилолтоор ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлээ.

### 3.3.3 Зөвлөмж

Илрүүлэлт 1: Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв нь анхан шатны баримтын бүрдэл дутуу 52.6 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр

төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг санхүүжүүлэхгүй байх

**Илрүүлэлт 2:** Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв нь тайлант онд 37 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээт ажлын төлбөрийн урьдчилгааг шилжүүлэхдээ урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй, шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", Сангийн сайдын А/229 дүгээр тушаалын хавсралтын 9 дүгээр бүлэг 9.1-д "Урьдчилгаа нь урьдчилж төлсөн зардал болон урьдчилж төлсөн тооцооноос бүрдэнэ. Энэ нь тайлангийн үед мөнгөөр гарсан боловч дараагийн тайлант үеийн зардал буюу бараа, үйлчилгээгээр тооцогдох ирээдүй цагийн зарлагыг илэрхийлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажил гүйлгээг хууль тогтоомж, стандартад заасны дагуу үнэн зөв бүртгэж байх.

**Илрүүлэлт 3:** Кибер аюулгүй байдлын ажлын алба нь батлагдсан төсвийг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулаагүй, бараа үйлчилгээний бусад зардлаас 33.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.3-т "эдийн засгийн ангиллаар", Сангийн сайдын 190 дүгээр тушаалын хавсралтад 210901:"Бараа үйлчилгээний бусад зардал: Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбоотой гарах бусад бараа, үйлчилгээнд төлөх зардал буюу энэ ангилалд тусгайлан заагдаагүй боловч хууль, тогтоомж, эрх зүйн бусад шийдвэрийн хүрээнд зөвшөөрөгдсөн, ажил, үйлчилгээ үзүүлэгчид төлөх ёстой төлбөр хураамжууд энд хамаарна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулж байх.

**Илрүүлэлт 4:** Кибер аюулгүй байдлын ажлын алба нь өөрийн батлагдсан төсвөөс өөр төсөв захирагчийн чиг үүрэгт хамаарах 19.3 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38-д "төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Өөрийн чиг үүрэгт хамааралгүй зардлыг санхүүжүүлэхгүй байх.

**Илрүүлэлт 5:** Кибер аюулгүй байдлын ажлын алба нь тайлант онд 4 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээт ажлын төлбөрийн урьдчилгааг шилжүүлэхдээ урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", Сангийн сайдын А/229 дүгээр тушаалын хавсралтын 9 дүгээр бүлэг 9.1-д "Урьдчилгаа нь урьдчилж төлсөн зардал болон урьдчилж төлсөн тооцооноос бүрдэнэ. Энэ нь тайлангийн үед мөнгөөр гарсан боловч дараагийн тайлант үеийн зардал буюу бараа, үйлчилгээгээр тооцогдох ирээдүй цагийн зарлагыг илэрхийлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажил гүйлгээг хууль тогтоомж, стандартад заасны дагуу үнэн зөв бүртгэж байх.

#### **4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй харьяа байгууллагуудад 14,463.2 сая төгрөгийн 3 албан шаардлага, 212.8 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна.

##### **Түүврийн байгууллагууд**

###### **4.1.1 Зөвлөмж**

Илрүүлэлт 1: Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба нь цалингаас бусад таван саяас дээш орлогын 148.3 сая төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 31.6 сая төгрөгийн 4 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээллээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт "Мэдээлэл үнэн зөв, бодитой байх", 4.1.3 дах заалт "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээллэдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх

Илрүүлэлт 2: Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв нь цалингаас бусад таван саяас дээш орлогын 1,140.8 сая төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 55.7 сая төгрөгийн 5 гүйлгээг шилэн дансны цахим системд хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт "Мэдээлэл үнэн зөв, бодитой байх", 4.1.3 дах заалт "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээллэдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх

###### **4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан нийцлийн аудитаар нийт 28,424.5 сая төгрөгийн 23 зөрчил илэрснээс 14.9 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 1,166.5 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 27,243.1 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өгсөн байна.

##### **Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил**

###### **4.2.1 Зөвлөмж**

Илрүүлэлт: Төсвийн төслийн саналыг боловсруулахдаа хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний зардлыг өмнөх онуудын гүйцэтгэлд суурилж, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөөгүй, арга хэмжээг ажил үйлчилгээ, тоо үзүүлэлтээр дэлгэрэнгүй ангилан бэлтгээгүйгээс харьяа байгууллагууд нь чиг үүрэгт хамааралгүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлуудыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйл 22.6-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шат бүрд төсвийн ангиллыг дараах байдлаар хэрэглэнэ: 22.6.3-

т “төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх”, 22.6.4-т “төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн төслийн саналыг боловсруулахдаа судалгаанд үндэслэн зардлын ангилал, хэрэгжүүлэх арга хэмжээ бүрээр задлан бодит тооцоололтой боловсруулж байх.

## Түүврийн байгууллагууд

### 4.2.2 Албан шаардлага

**Илрүүлэлт 1:** Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 3-р хавсралтаар батлагдаж 2023 онд хэрэгжиж дуусах "Мэдээлэл холбооны Дархан дэд төв /Дархан-Уул, Дархан сум, 1, 2, 3 дугаар баг/"-ийн хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, Бигмонголиа ХХК-тай 2022 оны 04 дүгээр сард 6,373.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Гэвч гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан хугацааг үндэслэлгүйгээр сунгаж 2024 оны 12 дугаар сарын 30-ны дотор ашиглалтад оруулахаар шийдвэрлэж, хугацаандаа хэрэгжээгүй гэрээний үлдэгдэл санхүүжилт 1,736.5 сая төгрөгийг Засгийн газрын тогтоолоор барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, тайлант онд гүйцэтгэлийг бүрэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно:" 40.2.1-т "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах", ГЕН-ийн 4.5.1-д "ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон", 4.7-д "ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл үүссэн болохыг гүйцэтгэгч нотлох үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гүйцэтгэгч гэрээнд тусгагдсан үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүссэнээс гэрээний нэмэлт өөрчлөлтийг үндэслэлгүйгээр сунгасан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

### 4.2.3 Зөвлөмж

**Илрүүлэлт 1:** Харилцаа холбооны оператор компаниудын үйл ажиллагааны урсгал зардал буюу харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх үйлчилгээг Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлж, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх ажлууд зэрэг дэд бүтэц бүтээн байгуулалтыг сайдын хөрөнгө оруулалтаас санхүүжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна." гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** БНҮҮС-ын хуулиар тодорхойлсон чиг үүрэгт заасан арга хэмжээг санхүүжүүлэхдээ сайдын хөрөнгө оруулалтын багцаас давхардуулан шийдвэрлэхгүй байх.

Илрүүлэлт 2: Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгүүдийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 5 дугаар зүйлийн 5.1-т "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар үе шаттай арга хэмжээ авч ажиллах.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДААНЫ НЭГТГЭЛ</b>													
<b>ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>													
1	ЦХИХХЯ	2	102.6	1	47.9	1	54.7	2	102.6	-	-	-	-
2	ТЦҮЗГ	6	683.9	-	-	6	683.9	6	683.9	-	-	-	-
3	КХЗТНТ	3	116.4	-	-	3	116.4	3	116.4	-	-	-	-
4	КАБЗАА	3	25.0	-	-	3	25.0	3	25.0	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>14</b>	<b>927.9</b>	<b>1</b>	<b>47.9</b>	<b>13</b>	<b>880.0</b>	<b>14</b>	<b>927.9</b>	-	-	-	-
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН</b>													
1	БНҮҮС	1	6,442.9	1	6,442.9	-	-	1	6,442.9	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>1</b>	<b>6,442.9</b>	<b>1</b>	<b>6,442.9</b>	-	-	<b>1</b>	<b>6,442.9</b>	-	-	-	-
<b>ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР</b>													
1	И-Монгол академи УТҮГ	1	88.5	1	88.5	-	-	1	88.5	-	-	-	-
2	МХС ХХК	5	116.0	1	0.5	4	115.5	2	61.4	3	54.6	3	54.6
3	МТҮП ТӨААТҮГ	3	4.3	1	2.9	2	1.4	1	2.9	2	1.4	2	1.4
4	Монгол шуудан ХК	1	83.8	-	-	1	83.8	1	83.8	-	-	-	-
5	ҮДТ УТҮГ	4	1,933.9	1	613.5	3	1,320.4	4	1,933.9	-	-	-	-
6	МЦХ ХК	6	4,793.7	2	1,876.0	4	2,917.7	6	4,793.7	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>20</b>	<b>7,020.2</b>	<b>6</b>	<b>2,581.4</b>	<b>14</b>	<b>4,438.8</b>	<b>15</b>	<b>6,964.2</b>	<b>5</b>	<b>56.0</b>	<b>5</b>	<b>56.0</b>
<b>Бүгд дүн</b>		<b>35</b>	<b>14,391.0</b>	<b>8</b>	<b>9,072.2</b>	<b>27</b>	<b>5,318.8</b>	<b>30</b>	<b>14,335.0</b>	<b>5</b>	<b>56.0</b>	<b>5</b>	<b>56.0</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ</b>											
<b>ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ</b>											
1	ЦХИХХС	1	-	-	-	1	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>											
1	ЦХИХХЯ	5	241.0	-	-	2	174.0	3	67.0	-	-
2	ТЦҮЗГ	10	225.6	3	11.1	1	48.6	6	165.9	-	-
3	КЗХТНТ	5	77.6	-	-	3	24.9	2	52.7	-	-
4	КАБЗАА	5	82.9	1	13.4	1	17.0	3	52.5	-	-
5	ЦХИХХС-Хөрөнгө оруулалт	2	295.4	-	-	2	295.4	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>27</b>	<b>922.5</b>	<b>4</b>	<b>24.5</b>	<b>9</b>	<b>559.9</b>	<b>14</b>	<b>338.1</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САН</b>											
1	БНҮҮС	5	1,009.5	1	59.0	4	950.5	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>5</b>	<b>1,009.5</b>	<b>1</b>	<b>59.0</b>	<b>4</b>	<b>950.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР</b>											
1	И-Монгол Академи УТҮГ	2	78.0	-	-	-	-	2	78.0	-	-
2	МХС ХХК	2	24.5	-	-	-	-	2	24.5	-	-
3	МТҮП ТӨААТҮГ	2	2.8	1	0.4	1	2.4	-	-	-	-
4	Монгол шуудан ХК	4	30.2	1	2.2	2	3.8	1	24.2	-	-
5	РТҮС УТҮГ	8	108.6	2	15.5	1	12.1	5	81.0	-	-
6	ҮДТ УТҮГ	1	193.8	-	-	-	-	1	193.8	-	-
7	МЦХ ХК	5	1,839.7	-	-	3	1,667.4	1	7.8	1	164.5
<b>Нийт дүн</b>		<b>24</b>	<b>2,277.6</b>	<b>4</b>	<b>18.1</b>	<b>7</b>	<b>1,685.7</b>	<b>12</b>	<b>409.3</b>	<b>1</b>	<b>164.5</b>
<b>Бүгд дүн</b>		<b>57</b>	<b>4,209.6</b>	<b>10</b>	<b>231.1</b>	<b>20</b>	<b>3,066.6</b>	<b>26</b>	<b>747.4</b>	<b>1</b>	<b>164.5</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ</b>									
<b>ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>									
1	ЦХИХХЯ	1	26.8	-	-	1	26.8	-	-
2	ТЦҮЗГ	1	152.8	-	-	1	152.8	-	-
3	КХЗТНТ	1	-	-	-	-	-	1	-
4	КАБЗАА	1	179.9	-	-	-	-	1	179.9
<b>Нийт дүн</b>		<b>4</b>	<b>359.5</b>	-	-	<b>2</b>	<b>179.6</b>	<b>2</b>	<b>179.9</b>
<b>ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР</b>									
1	И-Монгол Академи УТҮГ	1	14,283.6	-	-	1	14,283.6	-	-
2	РТҮС УТҮГ	1	32.9	-	-	-	-	1	32.9
3	ҮДТ УТҮГ	1	-	-	-	-	-	1	-
<b>Нийт дүн</b>		<b>3</b>	<b>14,316.5</b>	-	-	<b>1</b>	<b>14,283.6</b>	<b>2</b>	<b>32.9</b>
<b>БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ</b>									
<b>ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ</b>									
1	ЦХИХХС	1	-	-	-	-	-	1	-
<b>Нийт дүн</b>		<b>1</b>	-	-	-	-	-	<b>1</b>	-
<b>ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ</b>									
1	ЦХИХХЯ	4	490.5	-	-	1	368.7	3	121.8
2	ТЦҮЗГ	3	211.5	-	-	1	37.7	2	173.8
3	ЦХИХХС-Хөрөнгө оруулалт	3	26,824.7	-	-	1	-	2	26,824.7
<b>Нийт дүн</b>		<b>10</b>	<b>27,526.7</b>	-	-	<b>3</b>	<b>406.4</b>	<b>7</b>	<b>27,120.3</b>
<b>ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР</b>									
1	И-Монгол Академи УТҮГ	2	648.2	-	-	2	648.2	-	-
2	МТҮП ТӨААТҮГ	1	-	-	-	-	-	1	-
3	Монгол шуудан ХК	7	43.4	2	12.7	1	8.9	4	21.7
4	РТҮС УТҮГ	2	204.1	-	-	1	103.0	1	101.1
5	МЦХ ХК	1	2.2	1	2.2	-	-	-	-
<b>Нийт дүн</b>		<b>13</b>	<b>897.9</b>	<b>3</b>	<b>14.9</b>	<b>4</b>	<b>760.1</b>	<b>6</b>	<b>122.8</b>
<b>Бүгд дүн</b>		<b>31</b>	<b>43,100.6</b>	<b>3</b>	<b>14.9</b>	<b>10</b>	<b>15,629.7</b>	<b>18</b>	<b>27,455.9</b>